



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 10 сарын 10 өдөр

Дугаар 385

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

“Төв-А33А” төрийн өмчит хувьцаат компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар Сангийн сайдын 2012 оны 264 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг зөрчиж 2017 онд 182,9 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй, Төсвийн тухай хуулийн 6.4.1-д заасан “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.2-д заасан “Төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх” заалтыг зөрчиж 2.2 сая төгрөгийн үргүй зардал гаргасан зэрэг нийт 185.1 сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглэж, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 20 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. “Төв-А33А” төрийн өмчит хувьцаат компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэн дүнг 2019 оны дөрөвдүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт танилцуулахыг “Төв-А33А” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай

2.1. Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдалд хяналт тавьж ажиллах үүргээ хангалтгүй биелүүлсэн “Төв-А33А” төрийн өмчит хувьцаат компанийн холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох,

3. “Төв-А33А” төрийн өмчит хувьцаат компанийн захирал М.Ганбаатарт дотоод хяналтыг сайжруулж, дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай:

3.1. Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг арилгах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажиллах;

3.2. Худалдан авах ажиллагаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөж ажиллах, үүргээ хангалтгүй биелүүлсэн холбогдох албан тушаалтанд хууль тогтоомжид заасан хариуцлага тооцох;

3.3. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8-д заасны дагуу үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг шинээр худалдан авахдаа төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрийг үндэслэж, зорилтот түвшингийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй хөрөнгө худалдан авахгүй байх;

0000802


3.4. Компанийн бизнес төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний боловсруулалтыг сайжруулж, хяналт тавьж ажиллах;


3.5. Монгол Улсын Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2 дэх заалтыг мөрдөж, гэрээгээр худалдаж авахаар тооцсон бараа материал, ажил үйлчилгээний үнээс 10 хувийн татварыг суутган тооцож, төсөвт төвлөрүүлэх;

3.6. Санхүүгийн үйл ажиллагаанд Төсвийн тухай хуулийн 6.4.1-д заасан "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.2-д заасан "Төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх" заалтыг мөрдөж ажиллах;

3.7. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах төлөвлөгөөний биелэлтийг 2019 оны дөрөвдүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх;

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.





Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2019 оны 10 дугаар сарын 09 нь өдрийн
395..дугаар тогтоолын хавсралт

Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг арилгах арга хэмжээний жагсаалт

№	Зөрчил, дутагдлын утга	Хариуцах эзэн	Дүн /мян.төгрөг/	Зөрчил дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгалгүй худалдан авсан шатахуун, бараа, ажил, үйлчилгээ	Захирал М.Ганбаатар Ерөнхий ня-бо О.Баянтуул	182,935.60	Сангийн сайдын тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ыг мөрдөж ажиллах
2	МХГ-ын шалгалтаар илэрсэн зөрчлийн дагуу төлсөн актын төлбөр	Захирал М.Ганбаатар Ерөнхий ня-бо О.Баянтуул	2,200.00	Монгол Улсын төсвийн тухай хуулийг мөрдөж ажиллах,
	Дүн		185,135.60	

**“ТӨВ АЗЗА” ТӨХК-ИЙН
2017 ОН, 2018 ОНЫ САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН
ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ТАЙЛАН**

2019 оны 8 дугаар сарын 18

Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий зүйл

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7.4, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 66 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 12 дугаар тогтоолоор баталсан Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд баримтын хяналт шалгалт хийх төлөвлөгөөний дагуу Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын баталсан удирдамжаар “Төв-АЗЗА” ТӨХК-ийн 2017 он, 2018 оны оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд баримтын шалгалтыг тус хэлтсийн мэргэжилтэн, улсын ахлах байцаагч Н.Ган-Эрдэнэ, мэргэжилтэн Т.Анхбаяр нар 2019 оны 6 дугаар сарын 25-ны өдрөөс ажлын 7 хоногт багтаан хийлзээ.

Шалгалтад “Төв-АЗЗА” ТӨХК-ийн үйлдвэрлэлт борлуулалт, санхүү, техник эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн биелэлт, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, мөнгөн хөрөнгийн зарцуулалт, байгууллагын авлага, өглөгийн байдал, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай” хууль болон зохих журам, зааврын дагуу худалдан авалтыг төлөвлөн зохион байгуулж, тайлагнасан байдал, эд хөрөнгө, бараа материал, хандив тусlamжийн зарцуулалт зэрэг асуудлуудыг хамруулж, холбогдох хууль тогтоомж болон бусад эрх зүйн актуудыг удирдлага болгов.

Шалгалтад хамрах хугацааны санхүүгийн баримтанд гарын үсгийн нэгдүгээрийг захирал М.Ганбаатар, гарын үсгийн хоёрдугаарыг ерөнхий нягтлан бодогч О.Баянтуул нар зурж хөрөнгө мөнгийг захиран зарцуулж иржээ.

Хоёр. Үндсэн үйл ажиллагааны талаар:

2.1 “Төв АЗЗА” ТӨХК-ийн зорилго, үйл ажиллагаа:

Монгол Улсын Авто замын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-д “Авто тээврийн хэрэгсэл саадгүй зорчиход авто замыг бэлэн байлгах”, Компанийн дүрмийн 2.1-д “Төрийн захиргааны байгууллагаас баталгаажуулсан улсын чанартай авто замын байгууламжийн засвар, арчлалтыг төрийн захиргааны байгууллагатай байгуулсан “Зам засвар, арчлалтын гэрээ”-ний дагуу Төв аймгийн хэмжээнд зохион байгуулж, түүгээр өнгөрч байгаа тээврийн хэрэгслэлийн хөдөлгөөнийг жилийн туршид саадгүй байлгах үүргийг бүрэн хангаж, ашгийн төлөө ажиллахад оршино” гэж тус байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Тус компани нь Улаанбаатар-Мандалговь /A0201/ чиглэлд 153.81 км асфальтбетон зам, Өндөрдов-Зуунмод-Налайх /A25/ чиглэлд 28.3 км зам,

Өндөрширээт сумын Хэрмэн дэнжийн 336 у/м төмөрбетон гүүр бүгд 182.11 км асфальтбетон хучилттай зам, 336 у/м төмөрбетон гүүрийн засвар арчлалтын ажлыг гүйцэтгэхийн зэрэгцээ орон нутгийн чанартай зам гүүрийн засварын ажлыг гүйцэтгэж байна.

2.1. “Төв АЗЗА” ТӨХК-ийн 2017 он, 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн биелэлт

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 296 дугаар тогтоол, 63 дугаар тогтоол, 2017 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 611 дүгээр тогтоолоор “Төв АЗЗА” ТӨХК-ийн 2017, 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталжээ. Компанийн 2017 оны үйлдвэрлэлт, борлуулалттай холбоотойгоор 2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн 367 дугаар тогтоолоор өөрчөлт оруулсан байна.

“ТӨВ АЗЗА” ТӨХК-ИЙН 2017-2018 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИНГИЙН 2017ОН, 2018 ОНЫ БИЕЛЭЛТ

/сая.төгр/

Д/д	Үзүүлэлтүүд	2017 он		Харьцуулалт		2018 оны		Харьцуулалт			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Тоо	Хувь	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	төлөвлөгөөтэй	өмнөх оноос	тоо	хувь
1	Бүтээгдхүүн үйлдвэрлэлт	775.6	1,120.5	345.0	44	811.6	2,787.1	1,975.5	243	1,666.6	149
	Улсын чанартай 33A-ын ажил	407.4	562.4	155.0	38	407.4	687.2	279.8	69	124.8	22
	Орон нутгийн чанартай 33A	156.0	166.4	10.4	7	156.0	433.9	277.8	178	267.4	161
	Барилга угсралт	212.2	391.7	179.6	85	228.2	1,619.4	1,391.2	610	1,227.7	313
2	Нийт орлого	775.6	1,120.5	345.0	44	811.6	2,787.1	1,975.5	243	1,666.6	149
	Түрээсийн орлого	-	12.3	12.3		20.0	46.7	26.7	133	34.3	278
3	Нийт зардал	775.2	1,117.1	341.9	44	808.8	2,780.7	1,971.9	244	1,663.6	149
	Үүнээс: Удирдлагын зардал	210.9	152.3	(58.6)	(28)	186.0	148.3	(37.7)	(20)	(4.0)	(3)
4	Татварын өмнөх ашиг	0.4	3.4	3.0	768	2.8	6.4	3.6	128	3.0	87
5	Цэвэр ашиг/ алдагдал/	0.4	2.9	2.5	701	2.5	5.8	3.3	128	2.9	103
6	Төсвийн телбер	179.5	273.0	93.5	52	256.9	158.5	(98.4)	(38)	(114.5)	(42)
	Орлогын татвар	-	6.9	6.9		0.3	0.6	0.3	129	(6.3)	(92)
	НӨАТ	-	206.7	206.7		143.6	0.1	(143.5)	(100)	(206.6)	(100)
	Хувь хүний орлогын албан тат	-	50.6	50.6		103.2	65.5	(37.7)	(37)	14.9	29
	Үл хөдлөх хөрөнгийн татвар	-	6.8	6.8		7.1	5.3	(1.8)	(25)	(1.5)	(22)
	Тээврийн хэрэгслийн татвар,	-	1.9	1.9		2.1	2.0	(0.1)	(3)	0.2	11
	Төрийн өмчийн ноогдол ашиг	-	0.2	0.2		0.5	0.3	(0.2)	(44)	0.1	72
	НДШ	-	72.6	72.6		78.9	84.6	5.7	7	12.1	17
11	Нийт ажиллагсдын тоо	0	0	(0.0)	(22)	0	0	(0)	(14)	-	-
12	Нийт цалингийн сан	349.9	321.9	(28.0)	(8)	315.7	344.6	28.9	9	22.7	7
	Нэг ажиллагчийн дундаж цалин	0.60	0.7	0.1	19	0.6	0.8	0.2	26	0.0	7
7	Бор.лтын нэг төгрөгт ногдох зард	0.0	0.0	0.0	0	0.0	0.0	-			
8	Нийт авлага	119.9	71.1	(48.8)	(41)	55.6	106.8	51.2	92	35.7	50
9	Нийт өглөг	650.6	244.2	(406.3)	(62)	457.3	231.8	(225.4)	(49)		
	Үүнээс: Богино хугацаат өглөг	650.6	244.2	(406.3)	(62)		231.8	(225.4)	-49	(12.4)	(5)
10	Хөрөнгө оруулалт		-			21.6	3.3	(18.3)	(85)	3	

“Төв АЗЗА” ТӨХК 2017 онд 775,6 сая төгрөгийн орлого олж, 775,2 сая төгрөгийн зардал гарган 0,4 сая төгрөгийн ашигтай ажиллахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 1,120,5 сая төгрөгийн орлого олж, 1,117.1 сая төгрөгийн зардал гарган 3,4 сая

төгрөгийн ашигтай ажилласан бол 2018 онд 2,787.1 мянган төгрөгийн орлого олж, 2,780.7 төгрөгийн зарлага гарган 6,4 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгө

/мян.төг/

		2017.12.31	2018.12.31	Харьцуулалт	
				Тоо	Хувь
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	26,347.5	14,946.2	(11,401.2)	(43.3)
1.1.2	Дансны авлага	71,071.5	106,805.8	35,734.2	50.3
1.1.6	Бараа материал	53,904.3	102,794.4	48,890.2	90.7
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/Тооцоо	(0.0)	34,554.3	34,554.3	
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	151,323.3	259,100.7	107,777.4	71.2
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	0.0	0.0	0.0	
1.2.1	Үндсэн хөрөнгө	742,517.9	989,204.0	246,686.1	33.2
1.2.2	Биет бус хөрөнгө	462.0	874,698.0	874,236.0	189,226.4
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	742,979.9	1,863,902.0	1,120,922.1	150.9
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	894,303.2	2,123,002.7	1,228,699.6	137.4
2.1.1.1	Дансны өглөг	24,645.9	17,216.0	(7,429.9)	(30.1)
2.1.1.3	Татварын өр	219,587.6	214,627.0	(4,960.6)	(2.3)
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	244,233.5	231,843.0	(12,390.5)	(5.1)
2.2	Өр төлбөрийн нийт дүн	244,233.5	231,843.0	(12,390.5)	(5.1)

2018 оны жилийн эцсийн байдлаар компанийн нийт хөрөнгө **2,123.0** сая төгрөг, үүнээс үндсэн хөрөнгө **1863.9** сая төгрөг, эргэлтийн хөрөнгө **259,1** сая төгрөг байна. Нийт хөрөнгө өмнөх оноос **1,228.7** сая төгрөгөөр өссөнөөс эргэлтийн хөрөнгө 107.8 сая төгрөг буюу 71.2 хувь, үндсэн хөрөнгө 1,120.9 сая төгрөг буюу 150.9 хувиар тус тус өссөн байна.

Мөнгөн хөрөнгө: “Төв АЗЗА” ТӨХК нь Худалдаа хөгжлийн банк, Хаан банк дахь харилцах дансуудаар төгрөгийн болон валютын гүйлгээг хийж иржээ. Байгууллагын 2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Санхүүгийн тайланд мөнгөн хөрөнгийн нийт үлдэгдэл 14.9 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 11.4 сая төгрөгөөр өссөн үзүүлэлт байна.

Авлага: 2017 онд авлага оны эхнээс 48,8 сая буюу 41.0 хувиар буурч 71,1 сая төгрөг болсон бол 2018 онд 35.7 сая төгрөгөөр өсөж, 106.8 сая төгрөг болсноор зорилтот түвшинд тусгагдсан үзүүлэлтийг /55.6 сая төгрөг/ хангаж чадаагүй байна. Авлага өссөн гол шалтгаан нь 2018 онд хийгдсэн зарим ажлын хөлс он дамжиж орсноос шалтгаалжээ.

Өглөг: 2017 оны эхэнд bogino хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 989,9 сая төгрөг байснаас тайлант хугацаанд 745,7 сая төгрөгөөр буурч оны эцэст 244,2 сая төгрөг болж, зорилтот түвшинд тусгагдсан үзүүлэлтийг 406.3 сая төгрөг буюу 62 хувиар бууруулж ажилласан бол 2018 онд өглөгийг 457.3 саяд барих зорилтот түвшингийн үзүүлэлт 231.8 сая болж, өглөгийг 225.4 сая төгрөг буюу 49 хувиар бууруулж төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлж ажилласан байна.

3. Үндсэн хөрөнгийн өөрчлөлтийн талаар:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухайн хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь заалт, 31 дүгээр зүйлд заасны дагуу Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын

2017 оны 05-р сарын 09-ны өдрийн 86 тоот тогтоолоор компанийн 15,1 сая төгрөгийг данснаас хасах шийдвэр гарсны дагуу хөрөнгөийг данснаас хассан. Мөн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 05-р сарын 16-ны өдрийн 238 тоот тогтоолоор тус компанийн ТҮЗ-аас тавьсан хүсэлтээр үндсэн хөрөнгө дуудлага худалдаагаар худалдаа, актлах, данснаас хасах зөвшөөрөл олгосоны дагуу 25,6 сая төгрөгийн хөрөнгийг актлаж, 266,3 сая төгрөгийн хөрөнгийг дуудлага худалдаагаар оруулсан байна. Дуудлага худалдаагаар 23,8 сая төгрөгийн орлого олжээ.

Хөрөнгийн дахин үнэлгээний талаар:

Монгол улсын Засгийн газрын 2016 оны 193-р тогтоолын дагуу Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын газар эзэмших, ашиглах эрхийг үнэлэх, санхүүгийн тайланд бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлэх ажлыг 2018 онд зохион байгуулжээ.

Нийт 1,114.3 сая төгрөгийн үнэлгээ бүхий хөрөнгийн дахин үнэлгээ хийгдэж, балансад тусгагдсан байна.

- Газар нийт 556,9 сая төгрөг. /5 ширхэг/
- Барилга байгууламж 550,1 сая төгрөг /21 ширхэг/
- Нийтийн эзэмшил 6,7 сая төгрөг /13 ширхэг/ тус тус нэмэгдсэн байна..

4. ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ДУТАГДАЛ

“Төв АЗЗА” ТӨХК-ийн 2017 он, 2018 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар нийт 185,135.6 мянган төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнд:

1. 4.1. Худалдан авалттай холбоотой зөрчил, дутагдал: “Төв АЗЗА” ТӨХК нь 2017 онд “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль, Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын дагуу худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, гүйцэтгэлийг тайлагнаагүй байна.

Тус компани 2017 онд нийт 182,935.6 мянган төгрөгийн бараа ажил үйлчилгээг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгуулж, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулаагүй байна.

/мян.төг/

№	Огноо	Гүйлгээний утга	Зарлага	Тайлбар
1	2017.06.29	Асфальтон	9,625.00	ХААТ-д тусаагүй
3	2017.08.14	Замын тэмдэгний үнэ	6,984.00	ХААТ-д тусаагүй
2	2017.09.29	Ажлын хөлс Замын тэмдэглэгээ	12,000.00	ХААТ-д тусаагүй
4	2017.10.12	Давсны үнэ	5,250.00	ХААТ-д тусаагүй
5	2017.10.19	Дугуйны үнэ	1,640.00	ХААТ-д тусаагүй
6	2017.11.12	Бетон зуурмаг	6,177.27	ХААТ-д тусаагүй
7	2017.12.19	Давс	7,000.00	ХААТ-д тусаагүй
8	2017 он	Шатахуун	134,259.33	ХААТ-д тусаагүй
		Дүн	182,935.60	

4.2. Үргүй зардал: “Төв АЗЗА” ТӨХК-ийн 2017-2018 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар касс, харилцахын баримт шалгахад 2018 онд байгууллагын буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан МХГ-аас хийсэн шалгалтаар 2,200.0 мянган төгрөгийн санхүүгийн зөрчил илэрч акт тавигдсан байна.

Энэ нь байгууллагын эрх захирагчаас төсвийн талаар хэрэгжүүлэх “Төсвийн тухай хууль”-ийн 6.4.1-д заасан “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.2-д заасан “Төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх” заалтыг тус тус зөрчсөн байна.

№	Огноо	Гүйлгээний утга	Зарлага
1	2018.06.12	МХГ-ын акт төлөв	2,200.00
		Дүн	2,200.00

5. САНАЛ ДҮГНЭЛТ, ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР

“Төв АЗЗА” ТӨХК 2017-2018 онд 1,117.1- 2,787.1 сая төгрөгийн орлоготой ажиллаж, орлогын төлөвлөгөөг 345.0 -1,975.5 сая төгрөгөөр давуулан биелүүлж, компанийн зорилтот түвшинд тусгагдсан ашгийн төлөвлөгөөг биелүүлж ажиллажээ. Мөн зорилтот түвшинд тусгагдсан авлагыг 2017 онд 48,8 сая төгрөгөөр бууруулж, 2018 онд 51.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж ажилласан бол өглөгийн хязгаарыг 2017 онд 406,3 сая төгрөг буюу 62 хувиар, 2018 онд 22,5.4 сая төгрөг буюу 49 хувиар бууруулж ажилласан байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн 102 дугаар тогтоол, 2019 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 180 дугаар тогтоолоор Төв-АЗЗА төрийн өмчит хувьцаат компанийн 2017 он, 2018 оны үйл ажиллагаа, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, гүйцэтгэх захираал М.Ганбаатартай байгуулсан контрактын гэрээний биелэлтийг “Сайн” гэж дүгнэсэн байна.

“Төв АЗЗА” ТӨХК-ийн үйл ажиллагаанд дээрх эерэг сайн үр дүн байгаа хэдий ч 2017 он, 2018 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Монгол Улсын төсвийн тухай хууль, Нягтлан бodoх бүртгэлийн тухай хууль зөрчиж 212,5 сая төгрөгийн зөрчил, дутагдал гаргажээ. Санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн дээрх зөрчил дутагдлыг арилгах асуудлын хурээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

1. Худалдан авах ажиллагаанд “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль, Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”, журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 281 дүгээр тушаалыг мөрдөж ажиллах;

2. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8-д заасны дагуу үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг шинээр худалдан авахдаа төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрийг үндэслэж, зорилтот түвшингийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй хөрөнгө худалдан авахгүй байх;

3. Санхүүгийн үйл ажиллагаанд “Төсвийн тухай хууль”-ийн 6.4.1-д заасан “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.2-д заасан “Төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх” заалтыг мөрдөж ажиллах,

Танилцсан:


А.Дагвадорж
/Дэд дарга/

Хянасан:

Ц.Түвшинзаяа
/Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтсийн дарга, Улсын ахлах байцаагч/


Ө.Батбаатар
/Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн,
Улсын ахлах байцаагч/

Тайлан
боловсруулсан:


Н.Ган-Эрдэнэ
/Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтсийн мэргэжилтэн, Улсын ахлах байцаагч/
Т.Анхбаяр

Зөвшөөрсөн:


М.Ганбаатар /“Төв АЗА” ТӨХК-н захирал/




О.Баянтуул /Ерөнхий нягтлан бодогч/